



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 11 сарын 07 өдөр

Дугаар А/120

Улаанбаатар хот

Амьсгалын замын халдварт өвчний  
үед авч хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.4.13, 8.1.18 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Амьсгалын замын халдварт өвчний дэгдэлтийн үед орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангуулах, иргэдэд зориулсан сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх чиглэлийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн /Б.Цогтбаатар/, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт хүүхдийн өвчний цогц менежментийн болон томуу, томуу төст өвчний талаар сургалтыг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудыг амьсгалын замын халдварт өвчний тандалт, эмчилгээ, оношилгооны удирдамж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв /Ш.Энхтөр/, Эрүүл мэндийн хөгжлийн төв /Ч.Бат-Эрдэнэ/, Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д тус тус даалгасугай.

3. Амьсгалын замын өвчлөлийн нөхцөл байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, халдвараас сэргийлэх, эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээг уялдуулан зохицуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн ажиллах удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Амьсгалын замын халдварт өвчний дэгдэлтийн хариу арга хэмжээг удирдлага, зохион байгуулалт, арга зүйгээр хангаж, цаг үеийн байдлыг долоо хоног тутамд мэдээлж, шийдвэрлүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга, Эрүүл мэндийн дэд сайд /Л.Бямбасүрэн/-д үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080457

Эрүүл мэндийн сайдын 2016 оны  
1.1. сарын 04 өдрийн 1/120 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: Л.Бямбасүрэн, Эрүүл мэндийн дэд сайд

Дэд дарга: Л.Төмөрбаатар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Ч.Баярмаа, Эмнэлгийн тусламжийн газрын мэргэжилтэн,  
Т.Хулан, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын  
Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд, хариуцан ажиллах хуваарь

| Дүүргийн нэр              | ЭМЯ, ЭТГ-ын<br>мэргэжилтэн | НЭМГ-аас хариуцах<br>ЭТХ-ийн мэргэжилтэн |
|---------------------------|----------------------------|------------------------------------------|
| Чингэлтэй дүүрэг          | Г.Оюунцэцэг                | Ж.Энхцэцэг                               |
| Сүхбаатар дүүрэг          | Ч.Баярмаа                  | Д.Ганцэцэг                               |
| Хан-Уул дүүрэг            | С.Алтанбагана              | Б.Баатарсүх                              |
| Сонгинохайрхан дүүрэг     | Ө.Энхмаа                   | Б.Баатарсүх                              |
| Баянгол дүүрэг            | А.Бархас                   | Б.Бадамханд                              |
| Баянзүрх дүүрэг           | М.Оюунчимэг                | Б.Бадамханд                              |
| Багануур дүүрэг           | Н.Тунгалаг                 | Т.Хулан ЭТХ-ийн дарга                    |
| Налайх, Багахангай дүүрэг | На.Болормаа                | Т.Хулан ЭТХ-ийн дарга                    |



Эрүүл мэндийн сайдын 2016 оны  
1.1 сарын 04 өдрийн 4/130 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

## АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Зорилго.

Амьсгалын замын халдварт өвчний өвчлөл, дэгдэлтийн нөхцөл, байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, халдвараас сэргийлэх арга хэмжээг хойшлуулалгүй авч, эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл чирэгдэлгүй үзүүлэх.

### Үйл ажиллагааны чиглэл:

1. Амьсгалын замын халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тодорхой хуваарь гарган түгээх,
2. Амьсгалын замын халдварт өвчний үед хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэх нөхцөл, боломжоор хангах,
3. Амьсгалын замын халдварт өвчний оношилгоо, эмчилгээнд нэн шаардлагатай эм, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах,
4. Өрхийн эрүүл мэндийн төвөөс 5 хүртэлх насны хүүхдийг батлагдсан хуваарь болон дуудлагын дагуу гэрээр үзэж тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, мэдээллийг нэгтгэх,
5. Эрсдэлт бүлгийн хүн ам, жирэмсэн эмэгтэй ахмад настан, тав хүртэлх насны хүүхдийн судалгааг өрх бүрээр гаргаж, онцгой хяналтанд авах,
6. Амьсгалын замын халдварт өвчний цаг үеийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар долоо хоног тутамд мэдээлж, тулгамдсан асуудлыг шуурхай шийдвэрлэн ажиллах,
7. Харьяаллын сургууль, цэцэрлэгийн хүүхдийн ирцэд хяналт тавьж, амьсгалын замын халдварт өвчний тандалтыг эрчимжүүлэх,
8. Амьсгалын замын халдвараас урьдчилан сэргийлэх талаар сургууль, цэцэрлэг, үйлчилгээний байгууллагад мэдээлэл хүргэж, тэнд ажиллагсдыг сургалт сурталчилгааны ажилд татан оролцуулах,
9. Амьсгалын замын халдварын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шаардлагатай нэмэлт санхүүжилтийг шийдвэрлэхэд орон нутгийн Засаг даргын тамгын газар, даатгалын байгууллагатай хамтарч зохицуулалт хийж ажиллах,
10. Томуу, томуу төст өвчний улиралд амьсгалын замын үрэвсэлтэй өвчтөнд богино хугацаанд үзүүлсэн эмчилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас гаргадаг болгох, өвчтэй хүүхдийн асран хамгаалагчид эмнэлгийн хуудас олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээг авах.

**Хугацаа:**

2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 01-ний өдөр

**Үр дүн.**

1. Амьсгалын замын халдварт өвчний үед хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохицуулалт сайжирсан байна .
2. Шаардлагатай арга хэмжээг хугацаа алдалгүй авч хэрэгжүүлсэн байна.
3. Шаардлагагүй эмнэлгийн хэвтэлтийг багасгана.